

МОНГОЛ ОРНЫ ГАЗАР НУТГИЙН ТӨВД НЭРИЙН ТУХАЙ

Л.Чулуунбаатар

Монгол орны газар нутгийн нэр судлах ажил сүүлийн жилүүдэд идэвхжиж байна. XIX зууны эхний хагасаас гадаадын монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов, П.Пеллио, Э.М.Мурзаев, В.Н.Дарбаев, Т.А.Бертагаев, В.А.Казакевич нар өөрсдийн судалгаандаа их бага хэмжээгээр оруулж байсан бол монголын судлаачид Х.Пэрлээ, Ш.Шагдар, Ч.Догсүрэн, А.Лувсандэндэв, О.Сүхбаатар нар харьцангуй сүүлд 70, 80-аад оны үед судалж эхэлсэн бөгөөд Д-р Д.Базаргүр, Э.Равдан, Ж.Сэржээ нар 2000 оноос хойш судалгаагаа зориулж дэлгэрүүлэн хөгжүүлсээр байгаа билээ. Ялангуяа доктор Э.Равдан 2004 онд “Монгол газар нутгийн нэрийн хэлбэр-утга зүйн судалгаа” хэмээх бүтээл хэвлүүлж, 2006 онд “Монгол газар нутгийн зүйлчилсэн толь” хэмээх бүрэн хэмжээний толь, мөн 2008 онд “Монгол орны газар нутгийн нэр зүй”, 2011 онд “Монгол газар нутгийн нэрийн хувьслын толь” гаргасан нь монгол орны газар нутгийн нэрийг бүрэн хэмжээгээр судлахад том хувь нэмэр болсон билээ. Доктор Ж.Сэржээ 2010 онд хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа” бүтээлдээ 6 хэвлэлийн хуудас “Газар нутгийн нэр” хэмээх бүхэл бүтэн 3-р бүлгээ зориулж нэрийн учир, гарал үүсэл, хувьслын талаар нарийн ангилал хийсэн байна. Берлин хотын Улсын номын санд хадгалагдаж байдаг Чин улсын үеийн газрын зургийн талаархи 180 гаруй зургийн бүртгэлийг 1961 онд проф. К.Сагастер (K.Sagaster) авгай хийж нийтэлсэн агаад эдгээр газрын зурагт тэмдэглэгдсэн бүх газрын орны нэрийн хэлхээсийг эрдэмтэн М.Халтод (M.Haltod) хийж хэвлүүлэн гаргасан билээ.¹ Сүүлийн жилүүдэд 2000 он гарсанаас хойш Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн профессор Фүтаки Хироши, Камимура Акира нар хуучин газрын зургийн талаар судалгаа хийж, төсөл хэрэгжүүлэн 2005 онд “Монголын хуучин газрын зурагт үзүүлсэн газар нутаг” (*Landscapes Reflected in Old Mongolian Maps*) хэмээх номыг Токиод хэвлүүлсэн билээ. Энэхүү судалгааны номд ТГСИС-ийн номын санд хадгалагдаж байгаа газрын зураг, нутгийн цэсийг фото зургийн хэлбэрээр оруулснаас гадна эдгээр материалыг судалсан өгүүллүүдийг бас нийтэлсэн нь нэр судлалын хувьд олон зүйлийг харж болохоор байгаа юм.

¹ Futaki Hiroshi, Kamimura Akira, “Landscapes Reflected in Old Mongolian Maps”, TUFU, 2005, p VII

Л.Чулуунбаатар

МУИС-ийн Монгол Хэл Соёлын Сургууль
oyunavral@yahoo.com

Фүтаки Хироши, Камимура Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

Ер нь газар усны нэр бүхэн уул нутагт оршин амьдарч ирсэн ард түмний ахуй амьдралын өвөрмөц онцлогуудтай нь нягт холбоотой байдаг учир тэдгээр улс үндэстний түүх, эдийн засаг, хэл соёл, зан заншил, шүтлэг бишрэл, нүүдэл суурьшил, хүмүүсийн тухайн үеийн танин мэдэхүйн хэр хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой мэдээллүүдийг өөртөө агуулж байдаг² болохоор дээрх судалгаанууд нь монгол орны түүх соёл, газар нутгийн нэрийн судлалд үнэт хувь нэмэр оруулж байна. Монгол нутгийн газар орны нэрд гадаад нэр харьцангуй цөөхөн байдаг боловч Монгол орон төв Азийн цээжинд оршиж, Ази Европын энгээр төр улсаа байгуулж, олон орны түүх, шашин соёлтой нягт холбоотой явсан тул цөөн бус нэр үлдэж хоцорсон буюу шинээр бий болж, бас тэр нь дахин хувьсан өөрчлөгдөж байдаг нь мэдээж хэрэг билээ. Ялангуяа XV зуунаас Монгол нутагт бурхны шашин, буддын соёл дэлгэрсэнтэй холбогдон төвд, санскрит нэрээр нэрлэсэн газар орны нэр бий болсон билээ. Монгол хүмүүсийн нэрэнд маш олон төвд нэр байдагтай харьцуулбал газар орны нэр тийм ч их биш юм. Монгол орны газар нутгийн төвд нэрийн тухай анхны бие даасан өгүүллийг 1981 онд Доктор А.Лувсандэндэв “Монгол орны газар нутгийн төвд нэрийн тухай” нэртэйгээр бичиж 1986 оны “Хэл зохиол” сэтгүүлд хэвлүүлсэн билээ. Үүндээ:

1. Байгаль, газар зүйн онцлог нэрс

2. Түүхэн үйл явдал, эх оронч үзэл санаатай холбогдолтой нэрс гэж ерөнхийд нь хоёр хуваагаад хоёр дахь ангилалынхаа дэд бүлэгт Шашин шүтлэгтэй холбогдолтой нэрс гэдэгт төвд нэрсийг оруулсан байна. Жишээлбэл: “Дүнжингарав /Улаанбаатар хотын өмнө этгээдэд/, Шадавлин /Улаанбаатарын умар этгээдэд/, Дамбадаржаа (Улаанбаатарын умар этгээд/ байна гээд Дүнжингарав гэдэг нь түвдээр *mdun skyong dkar po* монголчилбол «Өмнийг тэтгэгч Цагаан» гэсэн үг, эртний бөөгийн ёсны Богд уулын эзэн савдгийг шарын шашны номын цагаан зүгт оруулан номхотгосон хэмээн буддын шашны лам нар ийнхүү нэрлэжээ. Дамбадаржаа гэдэг нь хуучин бичгийн хэлний Дамбадаржайлин, түвд хэлний *bstan pa dar rgyas*, гэдгийг ярианы хэлэнд товчилсон нь бөгөөд монголчилбол «Шашныг дэлгэрүүлэх хийд» гэсэн уг юм. Сэрүүн Сэлбийн дэнж, Бэлх сэлхийн аманд буддын шашны анхны хүрээ байгуулж, уг хийдийг тийнхүү «Шашныг дэлгэрүүлэх хийд» гэж нэрлэсэн түүхтэй аж³ хэмээн голдуу төвд нэрийн утгыг тайлбарлахыг ихэд чухалчилсан байна. Тэгээд цааш нь мөн өгүүлэлдээ “Гэвч Монгол орны газар усны түвд нэр бүхнийг бурхны шашинтай холбогдолтой гэж үзэж болохгүй. Газар усны түвд нэрийг ажиглан үзэхэд нэрлэх зарчим нь монголч үгээр нэрлэхтэй нэгэн адил байна.”⁴ хэмээн дүгнэсэн нь одоогийн өндөрлөгөөс харахад ихээхэн учир дутагдалтай дүгнэлт байх бөгөөд харин үзэл суртлын хатуу хяналттай, шашин бурхны тухай хамаагүй дуугарч болохгүй тэр цаг үеийн тэр бодлогод тааруулсан дүгнэлт болсон байна. Өөрөөр хэлбэл “Монгол орны газар усны түвд нэр бүхнийг бурхны шашинтай холбогдолтой гэж үзэж болохгүй.”⁵ хэмээсний учрыг огт тайлбарлалгүй орхисон нь үзэл суртлын хатуу хяналтаас өгүүллээ бултуулсан хэрэг байх хэмээн үзэхэд таарах юм. Тэгээгүй бол энэ өгүүлэл хэвлэгдэхгүй ч байсан байх магадлалтай. Монгол газар нутгийн төвд нэрс яахын аргагүй бурхны шашин болон буддын соёлтой нягт холбоотой байгаа билээ. Үүнийг Улаанбаатар хотын эргэн тойронд байгаа төвд нэрсээс харж болно. Жишээлбэл дээр Д-р А.Лувсандэндэвийн товч тайлбарласан Дамбадаржаа хэмээх нэр нь хийдийг нэрлэсэн нэр хэмээх тайлбар байгаа бол “Нийслэл хүрээг тойрсон олон сүм хийдүүдийн нэг нь “Долоон бурхан” буюу Дамбадаржайлан хийд, хүрээний хойт талаар орших арваад хийдийн хамгийн эртний бөгөөд бас хамгийн том нь Дамбадаржайлин хийд юм. Энэ хийд хүрээнд ойрхон, байгалийн үзэсгэлэн бүрдсэн газар анх байгуулагдсан юм. Яг долоон бурхан од шиг байрлал бүхий долоон сүм дугантай, шөнө болохоор долоон том зул асаадаг тус бүр шилэн хорготой байсан гэдэг. Тэгээд хүрээнийхэн шөнө хойшоо

² Ж.Сэржээ, “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа” УБ., 2010, х 131

³ А.Лувсандэндэв, “Монгол орны газар усны түвд нэрийн учир”, Хэл зохиол судлал, Улаанбаатар хот, 1986 он, х 5-6

⁴ Мөн тэнд, х 5

⁵ Мөн тэнд, х 5

харахад яг л газар дээр бас нэгэн долоон бурхан байгаа юм шиг харагддаг байснаас зуун зууны тэртээ энэ хийдийг “Долоон бурхан” хийд хэмээн нэрлэж их хүрээнийхэн шөнөд тийшээ мөргөж зальбардаг байсан гэнэ. Сүүлд энэ хийдийн тэргүүн хамбаар Дамбадаржаа ламтныг ажиллаж амьдарч байх үед хөгжлийнхөө оргилд хүрсэн, Дамбадаржаа ламтан ч их нэр хүндтэй хүн байсан учраас Дамбадаржаагийн хийд гэх болж улмаар тэр сүрлэг уул, дэлгэр сайхан ам нь Дамбадаржаа ламын нэрээр нэрлэгдэх болсон гэдэг.”⁶ хэмээсэн бас нэг домог мэдээ байна. Тэгэхлээр энэ хоёр мэдээг нягтлан тодруулах хэрэгтэй болж байгаа юм. Хуучин уламжлалаас харвал хүрээ хийдийг өөрийнх нэрээс гадна тэр хийд хүрээг эрхэлдэг нэр хүндтэй хамба, хутагт хувилгаадын нэрээр нэрлэх нь бас байжээ. Жишээлбэл: Жалханцын хүрээ, Заяын хүрээ, Ханд вангийн хүрээ, Саруул гүнгийн хүрээ, Хамба гэгээний хүрээ гэх мэтээр нэрлэсэн байдаг билээ. Ер нь нэрт эрдэмтэн, академич Б.Ринчен нарын 1979 онд эмхэтгэн нийтлүүлсэн “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”-ын доторх сүм хийдийн нэрийг ажиглан үзвэл ихэнх нь төвд нэртэй байгаа боловч 941 хүрээ, хийд, хурлын газраас зөвхөн 42⁷ нь дагнасан төвд нэртэй байна. Бусад нь оршин байгаа газар болон эрхэлэн хариуцсан ноёд түшмэд, хамба, хутагт хувилгаадын нэрээр нэрлэж заншсан байна. Гэхдээ аймаг тус бүрийн хүрээ хийдтэй харьцуулбал өчүүхэн бага оногдож байна. Баян-Өлгий аймгийн 10 хүрээ хийдээс дагнасан төвд нэртэй нь үгүй бөгөөд харин Моллагийн хийд гэх нэр байх бөгөөд Увс аймгийн 14 хүрээ хийдээс төвд нэртэй 2, Ховдын 19 –өөс 1, Завханы 43-аас 1, Хөвсгөлийн 64-өөс 2, Архангайн 78-аас 5, Булганы 76-аас 1, Сэлэнгийн 55-аас 1, Төвийн 92-оос 4, Хэнтийн 86-аас 3, Дорнотын 40-өөс 3, Сүхбаатарын 49-өөс 1, Дорноговийн 79-өөс 1, Дундговийн 67-оос 2, Өмнөговийн 45-аас 3, Өвөрхангайн 38-аас 1, Баянхонгорын 30-аас 1, Говь-Алтайн 24-өөс 1 нь төвд нэртэй байхад харин Улаанбаатарыг тойрсон 32 хүрээ хийд, хурлын сүмээс 9 нь төвд нэртэй байгаа юм. Эдгээрээс хүрээ хийдийн болон газрын нэр болж идэвхтэй хэрэглэгдэн үлдсэн нь Гандантэгчилэн хийд, товчоор Гандан хийд буюу Гандан мөн бас Гандангийн дэнж, Гандангийн айл гэх мэтээр, мөн Дашчойлин хийд буюу Дашчойлин, Дүнжингаравын сүм хэмээх байсан боловч одоо зөвхөн Богд уулын хүндэтгэл номын нэр болон үлджээ. Дээр дурдсан Дамбадаржаалин хийд нь Дамбадаржаагийн хийд, Дамбадаржаа хэмээх газрын нэр, Дамбадаржаагийн автобус зэргээр идэвхтэй хэрэглэгдэн үлджээ. Шадублин хийд хэмээх нэрийн хийд нь одоо байхгүй боловч газрын нэр болон үлдэж Шадублингийн зуслан гэх мэтээр хэрэглэх болжээ. Шадавлингийн зусланг мэдэхгүй хүн байхгүй. Энэ уужим дэлгэр ам нь битүү мод ургамлаар хучигдсан ёстой л диваажин гэмээр газар байсан гэдэг. Энэ ам дээшээ өгсөхөөр гурав салаалдаг. Гурван салаа амны уулзах бэлд хэсэг хусан төгөл, тэр хуснуудын дундаас Шадавлингийн рашаан ундардаг байв. Тэр рашаан булагийн зүүн талаар хошуурч тогтсон хадтай өндрийн энгэрт / зохиолчдын хорооны зуслан байгаа газар/ ганц өнчин сагалгар мод бий. Шадавлингийн хийдээс үлдсэн ганц шүтээн хэмээн хүмүүс хадаг яндар, судар ном зүүсээр одоо мөчир шилмүүс нь даахаа больсон байдаг. Энэ модны дэргэд хадтай толгойн энгэр дээр Шадав гэж гэлэн хүний байгуулсан цөөн хэдэн дуган сүмтэй бэсрэг хийд байсан гэдэг. Тэр гэлэнгийн нэрээр Шадав ламын хийд л гэдэг байжээ. Тэр эрхэм ламтан өндөр дээд зэрэг хэргэм авч Шадав гэлэн гэх болсноос хойш Шадав гэлэнгийн хийд гэх болж. Тэр нь цагийн саалтад сунжирсаар Шадав лингийн хийд болж тэр ам уул ус, булаг шанд бүхлээрээ Шадавлин хэмээн нэрлэгдэх болсон юм гэдэг.⁸ Богд уулын өвөрт орших Манзуширийн хийдийг хувилгаан хутагтынх нь нэрээр нэрлэсэнд оруулсан бөгөөд хүрээ хийд байхгүй болсон ч газрын нэр болон идэвхтэй хэрэглэгдэж байна. Богд хан уулын өвөрт орших Манзуширын хийд 300 гаруй жил ийн түүхтэйг тэр болгон мэддэггүй ч зун, намрын цагт энд аялагч, жуулчлагчдын хөл тасардаггүй.

Богд хан уулын магтаалд ...

Өвөр талдаа хийдтэй

Өргөн их шажинтай

⁶ www.mongoloron.blog.gogo.mn/read/entry152995

⁷ Б.Ринчен нар, “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”, УБ.,1979 он

⁸ www.mongoloron.blog.gogo.mn/read/entry152995

Махгалын шүтээнтэй

Манзушир ламын хийдтэй... гэж магтан дуулсан байдаг нь Манзушир хутагтын нэрээр нэрлэсэн гэдэг нь харагдаж байгаа юм. Харин ингэж хутагт хувилгаад, хүний нэрээр газар орон, сүм хийдийг нэрлэх явдал нь д-р А.Лувсадэндэвийн “Газар усны түвд нэрийг ажиглан үзэхэд нэрлэх зарчим нь монголч үгээр нэрлэхтэй нэгэн адил байна.”⁹ хэмээсэнтэй хийгээд д-р Ж.Сэржээгийн хэлсэн “Улс үндэстний түүх, эдийн засаг, хэл соёл, зан заншил, шүтлэг бишрэл, нүүдэл суурьшил, хүмүүсийн тухайн үеийн танин мэдэхүйн хэр хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой мэдээллүүдийг өөртөө агуулж байдаг”¹⁰ хэмээх тодорхойлолтуудтай бүрэн нийцэж байгаа юм. Үнэхээр ч Манзушир хийд нь асар баян түүхтэй байсан бөгөөд Халхын анхдугаар Манзушир хутагт долоон тангад ламын хамт 1733 оны хавар Богд хан ууланд хийд байгуулах газар шинжин олоод 1733 онд барьж эхлээд 1747 онд дуусгасан байна. “Манзуширын хийд 14-17 орчим барилгатай байсан” гэж яригддаг. Тус хийдийг нураан сүйтгэхээс өмнө буюу 1937 оны наймдугаар сарын 25-нд хийсэн тооллогоор дуган 10, байшин хоёр, гэр тав, хийдийн хэмжээтэй 500 шахам ам метр, барилгуудын чанар сайн гэж бүртгэгдэн үлджээ. Тухайн үед энэ хийдэд 300 лам, хувраг шавилан сууж ном хурдаг байв. Буддын гүн ухаан, судар тарнийн ёс, түүх, анагаах ухаан, хэл шинжлэл, зурхай, уран зохиол, одон орон, орчуулга зэрэгт мэргэшсэн билэг төгс мэргэд олон байсан гэдэг. Манзуширын хийд гоёмсог барилга, уран сийлбэр, зурмал хатгамал бурханы дүрүүд, хөгжмийн зэмсгүүд гээд шашин урлагийн хосгүй дурсгалуудаар алдартай байжээ. Түүний нэг нь дархан Дагва тэргүүтний урласан, дэлхийд цор ганц гэж хэлж болохоор алт мөнгөөр бүтээсэн «Сундуйн жүд», «Доржзодво» судар юм. Мөнгөн хуудсан дээр алтан үсгийг товойлгон сийлж бүтээсэн энэхүү гайхамшигт судруудад 2460 лан мөнгө орсон гэж эрдэмтэд тооцоолжээ. 1937 оны их хэлмэгдүүлэлтэд Манзуширын хийд өртөж, лам нарыг нь баривчилж, хөрөнгө зоорийг хураахад энэхүү гайхамшигт судрууд хамт хураагдаж Улаанбаатар хотод аваачсан байна. Манзушир ламтаны хийдэд дотоод яамны төлөөлөгчийн үүрэг хүлээж ажилласан Лувсанжамъян, Норов нар алтан, мөнгөн судрыг хурааж ирээд хэрхэх тухай Х.Чойбалсангаас асуухад «Алт, мөнгө шүр сувд их оруулсан үнэхээр сонин түүх дурсгалтай судар байна. Юу ч гэсэн хойноос /ЗХУ-аас/ хариу шийдвэр иртэл Судар бичгийн хүрээлэнд шилжүүлж, бат хадгалж бай» гэсэн тушаал буулгасан ажээ. Ийнхүү аз завшаанаар үлдсэн дэлхийд хосгүй алт, мөнгөн судрууд өдгөө Монгол Улсын Үндэсний номын санд нандигнан хадгалагдаж байна. Манзушир хийдийн сүүлчийн хутагт Цэрэндорж хилс хэргээр баригдан 1937 оны аравдугаар сард цаазлуулсан. Мөн тус хийдийн нэр бүхий 53 лам баривчлагдаж ихэнх нь цаазаар авахуулах ял сонссон байна. Тэднээс амьд үлдсэн нь цөөхөн ажээ. Ийнхүү олон зуун жилийн түүхтэй Манзуширийн хийд эзгүйрч, аймгийн яамны шийдвэрээр барилгуудыг нь ийш тийш зөөснөөр хийдийн туурь л үлджээ. Харин хийдийн хойт талын хаднууд дээр сийлсэн бурхадын зураг өнөөдөр ч гэсэн байсаар. Байгаль, түүхийн онцлог бүхий энэ газрыг аялал, жуулчлалын чиглэлээр ажиллуулах саналыг Төв аймгийн тухайн үеийн удирдлагууд гаргаж 1991 онд хийдийн туурин дээр аймгийн хөрөнгөөр «Манзушир хутагтын сэрүүн лавиран» сүмийг шинээр барьж, улмаар өргөтгөн 1993 онд музей болгожээ. Одоо энэ орчинд аялал, жуулчлалын «Манзушир тур» бааз ажилладаг. Дулааны улиралд Манзуширын музей нь аялагч, жуулчлагчдын хөл тасардаггүй газрыг нэг болдог. Бурханы шашны монголжсон итгэл үнэмшил, соёлыг түгээх төв болж байсан Манзуширын хийд нь дэлхийн анхны дархан цаазат газар Богд хан уулыг онгон төрхөөр нь хадгалж, хамгаалж ирэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр байна.¹¹ Ийнхүү Монгол газар орны төвд нэр идэхтэй хэрэглээнд байхад зарим нэг өөрчлөгдөн хэрэглээнээс гарч эхэлсэн нь ажиглагдаж байна. Д-р Э.Равдангийн “Монгол газар нутгийн нэрийн хувьслын толь”-иос үзвэл Засагт хан аймгийн нутаг дахь Баатар бээсийн хошууны

⁹ А.Лувсадэндэв, “Монгол орны газар усны түвд нэрийн учир”, Хэл зохиол судлал, Улаанбаатар хот, 1986 он, х 5

¹⁰ Ж.Сэржээ, “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа” УБ., 2010, х 131

¹¹ www.news.gogo.mn/t/53803

Гэмбэлийн хүрээ хэмээх газар 1922 онд ийм нэртэйгээ байсан бол 1952 онд Хонгорын хүрээ¹² хэмээх нэртэй болон өөрчлөгдсөн байна. Сайн ноён хан аймгийн Хөвсгөл нуурын Урианхайн хошуунд орших Дэчинравжаалингийн хүрээг 1915 онд ийн нэрлэж байсан бол газар нутгийн хуваарь 1926 онд Цэцэрлэг мандал уулын аймгийн Хөвсгөл далай, Бүрэн хан уулын хошуу болон өөрчлөгдөж хүрээний нэр нь Ханхын хүрээ¹³ болон өөрчлөгдсөн байна. Сэцэн хан аймгийн Эрх засгийн хошууны Түглэй гурван худаг хэмээх газар 1897 онд ийм нэртэй байгаад 1942-1943 онд Төгөл худаг¹⁴ нэртэй болсон байна. Түшээт хан аймгийн Эрдэнэ чин вангийн хошуунд 1907 онд Жалбаг гол хэмээх нэртэй байсан газар 1947-1950 онд Хөшөө уст гол¹⁵ хэмээн өөрчлөгдсөн байна. Ийнхүү Монгол газар нутгийн төвд нэр нь батжин бэхжихийн хажуугаар сулран бүдэгрэх болон өөрчлөгдөх үйл явц давхар явж байна. Үүнээс ажиглан үзэхэд хүрээ хийд олонтой байсан газар нутагт төвд нэртэй газар орон олон байх дүр зураг ажиглагдаж байгаа бөгөөд сүм хийдийн бүрэн устгасан газрын төвд нэр өөрчлөгдөн хувьссан нь бас ихэнх байна хэмээн ажиглагдаж байна. Д-р А.Лувсандэндэв, Ж.Сэржээ нар “Ринченжугнай нуур /Хөвсгөл, Цэцэрлэг сум/ түвдээр rin cben <byung gnall монголчилбол «Эрдэнэ гарах орон», Доной, Дугарт, Дунгар, Дүнжингарав, Дэдинлхүмбэ, Жанчивлин, Зотол, үун, Лхачинвандад, Намжил, Намнан, Номгон, Норовлин, Нороврээ уул /Дундговь, Цагаандэлгэр сум/ түвдээр nog bu gi монголчилбол «Чандмань уул» уул, Оцол, Поврон, Пунцаг, Пэрэнлэйлхүндэв, Самбалхүндэв, Сант, Сантмаргац, Сэвжидбалбар, Сэврээ, Сэлбэ, Туруун, Түдэвтэй, Түмбэ, Цайдам, Цамбабагарав, Цорж, Чарви, Чойр, Шадавлин, Шурагзай, Яйчил, Гандан нуур /төвд хэлний «төгс баясгалант» гэсэн утгатай dga Idan гэдэг үгээр нэрлэсэн/ Хөвсгөл аймаг, Цагаан-Уул сум/, Лүн /Хөвсгөл, Арбулаг сум/ Дашлүн гэж байгаад Лүн болсон бөгөөд түвдээр bkra shies lung «Өлзийт гол» гэсэн үгийн lung «гол» гэсэн нэрийтгэл нэр болон үлджээ”¹⁶ ¹⁷гэх мэтээр заримыг тайлбартай заримыг тайлбаргүй жагсаан бичсэн байгаа билээ. Дээрхийн маягаар нарийн түүвэрлэн утгын судалгааг давхар хийн Монгол газар нутгийн төвд нэрийн дэлгэрэнгүй судалгаа хийх , мөн нэрийн хувьслын судалгааг нарийвчлан хийх, түүх домогтой нь холбон судлах нь ч бас чухал болохыг энэхүү өгүүлээрээ гаргахыг оролдсон минь энэ болой.

НОМ ЗҮЙ

1. А.Лувсандэндэв, “Монгол орны газар усны түвд нэрийн учир”, Хэл зохиол судлал, Улаанбаатар хот, 1986 он
2. Э.Равдан, “Монгол газар нутгийн нэрийн хувьслын толь”, УБ., 2011 он
3. Б.Ринчен нар, “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”, УБ., 1979 он
4. Ж.Сэржээ, “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа” УБ., 2010
5. Futaki Hiroshi, Kamimura Akira, “Landscapes Reflected in Old Mongolian Maps”, TUFSS, 2005
6. www.mongoloron.blog.gogo.mn/read/entry152995
7. www.news.gogo.mn/r/53803

¹² Э.Равдан, “Монгол газар нутгийн нэрийн хувьслын толь”, УБ., 2011, х 16

¹³ Э.Равдан, “Монгол газар нутгийн нэрийн хувьслын толь”, УБ., 2011, х 37

¹⁴ Мөн тэнд х 82

¹⁵ Мөн тэнд х 114

¹⁶ А.Лувсандэндэв, “Монгол орны газар усны түвд нэрийн учир”, Хэл зохиол судлал, Улаанбаатар хот, 1986 он, х 5

¹⁷ Ж.Сэржээ, “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа”, 2010, х 160-161